



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/1



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНД СУРТАЛ
АВЛИГА ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	
Аргачлалын тайлбар.....	
I.Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III.Эрүүл мэнд	
IV.Гэмт хэрэг	
V.Үнэ.....	
VI.Төсөв.....	
VII.Хөдөө аж ахуй	
VIII. Аж үйлдвэр	
IXI.Тээвэр.....	
XI. Холбоо.....	
XII.Цаг агаарын мэдээ.....	
Хавсралт.....	

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараахь тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:**

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

- **Нийгмийн даатгал, халамж:**

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгий нхариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэрхэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.



✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг гнэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг СанхүүТөрийн сангийн Хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 01 дугаар сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 01 дугаар сард 301 болсноос 174 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 135 нь ажилгүй иргэд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 106 буюу 2.6 хувиар, өмнөх сарынхаас 31 ажил хайгч буюу 9.3 хувиар тус тус буурсан байна.

Эхний 01 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 13 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6 буюу 1.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн хэлтсээр эхний 01 сард 5 иргэн ажилд зуучлуулсны 1 нь буюу 20.0 хувь эмэгтэйчүүд байлаа.

Зураг. I.1

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй,
жил бүрийн эхний 01 сарын байдлаар



Ажил хайгч ажилгүй иргэдийн 62.2 хувийг бүрэн дунд, 31.1 хувийг дипломын болон бакалаврын, 14.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 11.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 3.0 хувийг суурь, 2.2 хувийг бага боловсролтой, 0.7 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.



I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 01 сард 28 эх амаржиж, 29 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 10 буюу 35.7 хувиар, хүүхдийн тоо 9 буюу 23.7 хувиар тус тус буурсан байна.

2016 оны эхний 01 сард нас баралт 62, бүртгүүлсэн гэр бүл 63, цуцалсан гэр бүл 20, үрчлэгдсэн хүүхэд 4 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 55 буюу 7.9 хувиар, үрчлэгдсэн хүүхдийн тоо 3 буюу 0.8 хувиар өсөж, бүртгүүлсэн гэр бүл 16 буюу 25.8 хувиар, цуцалсан гэр бүл 4 буюу 20.0 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд 65 иргэн нийслэл болон бусад аймгуудаас шилжин ирж, 51 иргэн нийслэл болон бусад аймаг руу шилжин явсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн иргэн 9 буюу 16.0 хувиар өсч, шилжин явсан иргэн 15 буюу 41.6 хувиар өссөн байна.

Зураг.I.3

Шинэ төрсөн хүүхдийн тоо,жил
бүрийн эхний 01 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 01 сард 3366.7 сая төгрөгөөр, зарлага 6553.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого -3331.1 сая төгрөг буюу 0.5 хувиар, зарлага 6553.9 сая төгрөг буюу 1.2 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 01 сард өмнөх оны мөн үеийнхээс -3331.1 сая төгрөгөөр буурхад тэтгэврийн даатгалын сангийн орлого -210.5 сая төгрөг буюу 6.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 01 сард 6553.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1036.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 729.4 сая төгрөг буюу 1.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 01 сард 945 хүнд 85.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 372 хүн буюу 2.0 хувиар, олгосон нийгмийн халамжийн үйлчилгээ 61.4 сая төгрөг буюу 1.9 хувиар өссөн байна. Нийгмийн халамжийн сан буурахад нөхцөлт мөнгөн тэтгэмж 9.1 сая төгрөг буюу 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 01 сард 718 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 267 хүн буюу 37.1 хувиар өсч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 61.4 сая төгрөг буюу 1.8 хувиар өссөн байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжинд 2016 оны эхний 01 сард 227 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 105 хүн буюу 1.8 хувиар өсөж, олгосон нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжийн хэмжээ 24.0 сая төг буюу 2.9 хувиар өссөн байна.

II.3 Дундаж цалин

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эхний 01 сарын мэдээгээр 151 байгууллагын 3264 даатгуулагч иргэн, үүнээс 165 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуудагчдын 1767.6 сая төгрөг, дундаж цалин 9843 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл Орон нутгийн өмчийн оролцоотой 5 аж ахуй нэгжийн 148 ажилтны цалин 78.1 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 527.9 мянган төгрөг, төсөвт 46 байгууллагын 1182 ажилтны цалин 811.0 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 686.1 мянган төгрөг, 6 ХХКомпанийн 31 ажилтны цалин 13.5 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 907.3 мянган төгрөг, 60 ХХКомпанийн 506 ажилтны цалин 270.0 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 1837.0 мянган төгрөг, бусад 14 байгууллагын 107 ажилтны цалин 67.9 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 4693.5 мянган төгрөг боллоо.




III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 01 сарын байдлаар 30 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 30 үүнээс 17 нь эрэгтэй, 13 нь эмэгтэй, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 3 буюу 9.0 хувиар, хүүхдийн тоо 30 буюу 9.0 хувиар тус тус буурсан байна.

Зураг III.1

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн
эхний 01 сарын байдлаар




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 ба 1000 амьд төрөлтөд 66.6 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдэл, гэрийн төрөлт, бүртгэгдээгүй болно.

Зураг III.2



0-5 насны хүүхдийн эндэгдэл, жил бүрийн
эхний 01 сарын байдлаар




Он гарсаар 10164 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 471 хүн буюу 4.6 хувиар өсч, 365 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 68 хүн буюу 15.7 хувиар буурсан байна.

2016 оны эхний 01 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 569 удаа гарсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2016 оны эхний 01 сард 33 осол гэмтлийн өвчлөл, Халдварт өвчин 13 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Осол гэмтлийн болон халдварт өвчлөлийн тоо,
жил бүрийн эхний 01 сарынбайдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 01 сард 13 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 10 хэрэг буюу 43.5 хувиар буурсан байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,
жил бүрийн эхний 01 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 7 буюу 50.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 4 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 буюу 20.0 хувиар буурч, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 60.0 байгаа нь өмнөх оны мөн үеэс 22.5 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 15 хүн гэмтэж, 2 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 12 буюу 2.0 хувиар, нас барсан хүн 0 байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,
жил бүрийн эхний 01 сарын байдлаар






Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 01 сард 7.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 5.7 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 548.2 сая төг буюу 98.7 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 139.0 сая төг буюу 96.1 дахин нэмэгдсэн байна.

2016 оны эхний 01 сард 77 хүн эрүүлжүүлэгдэж, 1 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 2 буюу 2.5 хувь, баривчлагдсан хүний тоо 13 буюу 92.9 хувиар тус тус буурсан байна.

Зураг IV.3

Албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан, эрх хасуулсан хүний тоо, жил бүрийн эхний 01 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2016 оны 01 сард 105.4 болж өмнөх сараас 0.5 хувиар хувиар өссөн байна.




Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 01 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2016. I 2015. I	2016. I 2015. XII	2016. I 2015. XII
Ерөнхий индекс	105.4	99.8	99.8
Хүнсний бараа, ундаа, ус	97.5	99.0	99.0
Согтууруулах ундаа, тамхи	97.8	100.3	100.3
Хувцас, бөс бараа, гутал	114.0	100.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.1	100.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	105.6	100.0	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
Тээвэр	100.7	100.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.4	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	114.9	100.3	100.3
Бусад бараа, үйлчилгээ	104.1	100.7	100.7

Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.5 хувиар өсөхөд гэр ахуйн барааны бүлэг 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг V.1

Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 01 дүгээр сар, (өмнөх сар=100%)





VI. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 1064.1 сая төг, гүйцэтгэлээр 1197.0 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 423.3 сая төг буюу 35.4 хувиар өсчээ. Орон нутгийн төсвийн нийт орлого өсөхөд 387.3 сая төгрөгөөр татварын орлого өссөн нь голлон нөлөөлжээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 1203.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 708.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 494.6 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 39.0 сая төг буюу 5.2 хувиар бага байна.

2016 оны эхний 1 сарын байдлаар авлагын үлдэгдэл 22.2 сая төг, өглөгийн үлдэгдэл 339.0 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлагын үлдэгдэл 12.0 сая төг буюу 117.6 хувиар өсч, өглөгийн үлдэгдэл 183.1 сая төгрөгөөр өссөн байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн
эхний 1 сарын байдлаар, сая төгрөгөөр



VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тооллогдсон төллөх насны 154821 хээлтэгч




малын 9 нь 2016 оны эхний 1 сард төллөсөн байна. Эм хонь 5, үнээ 4 төллөжээ. Гарсан төлийн 100.0 хувь буюу 9 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 49 толгойгоор бага байна.

2016 оны эхний 1 сард том малын зүй бус хорогдол 984 болж, өмнөх оны мөн үеийнхээс 952 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон мал байхгүй байна.


Зураг VII.1

Төл бойжилт, жил бүрийн эхний 1 сараар, толгойгоор



Зураг VII.2

Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 1 сараар, толгойгоор



VIII. Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 1 сард 5544.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2648.9 сая төгрөг буюу 47.8 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 2623.6 сая төг буюу 49.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 4947.3 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1548.3 сая төгрөг буюу 31.3 хувиар өслөө.



Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 4680.5 сая төг буюу 94.6 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,
жил бүрийн эхний 1 сар, сая төгрөгөөр



IX.ТЭЭВЭР

Авто тээврийн газар нь 2016 оны эхний 1 сарын байдлаар 1.8 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 378.7 мян.хүн км болж 1.0 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.


X. ХОЛБОО

Аймгийн Холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 1 сарын байдлаар нийт орлого 15.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 3.5 сая төг буюу 18.6 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 9.2 сая төг буюу 60.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 сая төг буюу 18.6 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт телефон цэгийн тоо 354 болж өмнөх оны мөн үеийнхээс 61 буюу 14.7 хувиар буурсан байна.

2016 оны эхний 1 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 15 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 3 байна.

Зураг X.1

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,
жил бүрийн эхний 1 сар, сая төгрөгөөр



XII. Цаг агаарын мэдээ

2016 оны 01 дугаар сард агаарын дундаж температур -23.1 хэм байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс -9.3 буюу 1.7 хэм хүйтэн, хамгийн их температур -8.6 хэм, хамгийн бага температур -3.6 хэм байлаа. Хөрсний температурыг авч үзвэл дундаж нь -23.8 хэм байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс -8.4 буюу 1.5 хэм хүйтэн, хамгийн их нь -6, хамгийн бага нь -36.8 хэм байлаа. Тундасны хэмжээ 1.3 мм байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 мм илүү тундастай, тундастай өдрийн тоо 2 байна. Салхины хурд хамгийн ихдээ 10 м/с байсан нь өмнөх оны мөн үеэс 2 м/с-ээр илүү байлаа.

2016 оны 02 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Говьсүмбэр аймгийн нутгаар агаарын температур 15-20 градус, буюу олон жилийн дунджийн орчим байна.

Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч шөнөдөө 22-27 градус, өдөртөө 10-15 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн эхний хагаст болон гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 13-18 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн байна.

Энэ сард Говьсүмбэрийн нутгаар нэг ба гуравдугаар арав хонгийн эхэн ба дунд үеээр бага зэргийн цас орно. Салхи нэгдүгээр арав хонгийн эхэн болон сүүл, хоёрдугаар арав хоногийн сүүлийн 16-18м/с, хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй байна.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 01 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 I	2016 I	Зөрүү	$\frac{2016 I}{2015 I} \%$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд					
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	38	29	-9	76.3
Ажил хайгч иргэдийн тоо, 01 дүгээр сарын эцэст	хүн	252	135	-117	53.6
Халдварт өвчнөөр өвчлөгчдын тоо	хүн	9	13	4	144.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	23	13	-10	56.5
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт					
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	773.7	1197.0	423.3	154.7
Татварын орлого	сая.төг	172.5	536.5	364	311.0
Татварын бус орлого	сая.төг	11.9	23.3	11.4	195.8
Хөрөнгийн орлого	сая.төг	0.7	-	-	-
Тусламжийн орлого	сая.төг	588.6	637.2	48.6	108.3
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	747.8	708.8	-39	94.8
Бараа үйлчилгээний зардал	сая.төг	636.2	705.8	69.6	110.9
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	сая.төг	111.6	-	-	-
Эдийн засгийн үзүүлэлтүүд					
Том малын зүй бусын хорогдол	тол	32	984	952	3075.0
- Тэмээ	тол	-	-	-	-
- Адуу	тол	-	26	-	-
- Үхэр	тол	1	53	52	5300.0
- Хонь	тол	12	323	311	2691.6
- Ямаа	тол	19	582	563	3063.2
Бойжуулсан төл	тол	58	9	-49	15.5
- Тэмээ	тол	-	-	-	-
- Адуу	тол	-	-	-	-
- Үхэр	тол	8	4	-4	50.0
- Хонь	тол	31	5	-26	16.1
- Ямаа	тол	19	-	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	2895.1	5544.0	2648.9	191.5
Тээврийн орлого	сая.төг	-	976.4	-	100.0
Холбооны орлого	сая.төг	18.8	15.3	-3.5	81.4



I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 01 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Ажил хайгч иргэнийн тоо	252	301	119.4
Үүнээс эмэгтэй	152	174	114.5
Ажлын байрны захиалга	6	13	216.6
Ажилд жуучлагдсан иргэд	2	5	250.0
Үүнээс эмэгтэй	1	1	100.0

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 01 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	6697.8	3365.7	50.3
Тэтгэврийн даатгалын сангийн	4223.4	2120.8	50.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	477.0	238.5	50.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	637.9	317.3	49.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	1169.6	5726.1	489.6
Ажилгүйдлын даатгалын сангийн	1242.7	6326.8	509.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	5517.9	6553.9	118.8
Тэтгэврийн даатгалын сангийн	4550.8	5280.2	116.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	483.3	1086.4	224.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2317.9	2309.8	99.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	689.7	1331.4	193.0
Ажилгүйдлын даатгалын сангийн	6180.0	8000.0	129.4

Тайлбар: *ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 01 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I		2016 I		$\frac{2016 I}{2015 I} \%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	573	40.9	945	85.6	164.9	209.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	451	32.7	718	61.5	159.2	188.0
Халамжийн тэтгэвэр	107	13.8	212	33.5	198.1	242.8
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	344	18.9	506	28.0	147.0	148.1
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	206	9.5	331	15.8	160.7	166.3
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	63	3.9	83	5.2	131.7	133.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	62	3.7	79	5.6	127.4	151.3
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	13	1.8	13	1.3	100.0	72.2
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	122	8.2	227	24.0	186.0	292.7
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	2	62.5	18	931.0	900.0	1489.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	23	1.2	56	6.5	243.5	541.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ	0	0	-	2.7	-	-
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	97	7.0	153	14.0	157.7	200.0
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	0	0	0	0	0.0	0.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	0	0	0	0	0.0	0.0



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 01 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Төрсөн эх	33	30	90.9
Амьд төрсөн хүүхэд	33	30	90.9
Эрэгтэй	13	17	103.8
Эмэгтэй	20	13	65.0
Амьгүй төрөлт	0	0	0.0
Нийт нас баралт	8	7	87.5
Эмнэлгийн нас баралт	3	1	33.3
Хоног болоогүй нас баралт	1	0	0.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2	100.0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2	100.0
Эмнэлгээс гарсан хүний тоо	433	365	84.3
Амбулаторийн үзлэг	9693	10164	104.9
Осол гэмтлийн өвчлөл	45	33	73.3
Халдварт өвчин	9	13	144.4



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	23	13	-43.5
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	14	7	-50.0
Өмчлөх эрхийн эсрэг	6	3	-50.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	1	1	0.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	0	1	1 нэгж
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	1	1 нэгж
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	2	0	2 нэгж
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод	17	12	29.4
14-16 насны	0	0	0.0
16-18 насны	4	2	-50.0
18-30 насны	5	4	-20.0
30-35 насны	3	4	33.3
35-с дээш	5	2	-60.0
Боловсрол – Дээд	2	2	0.0
Боловсрол - Тусгай дунд	3	0	-100.0
Боловсрол – Бүрэн дунд	6	6	0.0
Боловсрол – Бүрэн бус дунд	68	56	-100.0
Боловсрол – Бага	1	3	200.0
Боловсролгүй	0	1	1 нэгж
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	2	0.0
Ажилгүй иргэд үйлдсэн	3	8	166.7
Эмэгтэй хүн оролцсон	2	4	100.0
Хүүхэд оролцсон	1	0	-100.0
Бүлгээр үйлдсэн	1	1	0.0
Согтуугаар үйлдсэн	12	5	-58.3
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	23	13	-43.5
Гудамж талбайд	7	5	-28.6
Албан газарт	1	2	100.0
Гэр орон сууцанд	7	2	-71.4
Авто зам	0	0	0.0
Бусад газарт	8	4	-50.0
ГХ-н улмаас нас барсан	2	2	0.0
ГХ-н улмаас гэмтсэн	27	15	2.0
Учирсан хохирол / сая.төг /	555.2	7.0	-98.7
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	144.7	5.7	-96.1



V.1 Хэрэглээний үний индекс, 01 дүгээр сар, 2016.01, 2015.12, 2015.12 дугаар саруудтай харьцуулснаар

Барааны бүлгээр	2016-01 2015-01	2016-01 2015-12	2016-01 2015-12
Ерөнхий индекс	105.4	99.8	99.8
01. хүнсний бараа, согтууруулах бус ундаа	97.5	99.0	99.0
01.1 хүнсний бараа	97.4	98.9	98.9
01.1.1 талх, гурил, будаа	123.4	100.2	100.2
01.1.2 мах, махан бүтээгдэхүүн	67.5	95.6	95.6
01.1.4 сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	102.4	99.8	99.8
01.1.5 төрөл бүрийн өөх, тос	97.1	100.1	100.1
01.1.6 жимс, жимсгэнэ	107.8	106.5	106.5
01.1.7 хүнсний ногоо	92.9	96.9	96.9
01.1.8 саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколад	94.1	97.9	97.9
01.1.9 хүнсний бусад бүтээгдэхүүн	102.4	102.3	102.3
01.2 согтууруулах бус ундаа	100.3	100.2	100.2
02. согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	97.8	100.3	100.3
02.1 согтууруулах ундаа	101.0	100.9	100.9
02.2 тамхи	96.0	100.0	100.0
03. хувцас, бөс бараа, гутал	114.0	100.0	100.0
03.1 хувцас, бөс бараа	113.1	113.1	100.0
03.1.1 хөвөн, бөс бараа	128.9	100.0	100.0
03.1.2 бүх төрлийн хувцас	112.1	100.0	100.0
03.1.3 жижиг эдлэл, хэрэгсэл	123.0	100.0	100.0
03.2 гутал	116.4	100.0	100.0
04. орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	104.1	100.0	100.0
04.1 орон сууцны бодит түрээс	100.0	100.0	100.0
04.2 орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ	102.3	100.0	100.0
04.3 усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ	100.0	100.0	100.0
04.4 цахилгаан, хийн болон бусад түлш	105.6	105.6	100.0
05. гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	105.6	100.0	100.0
05.1 гэр ахуйн тавилга, хэрэгсэл, хивс болон шалны бусад дэвсгэр	100.7	100.0	100.0
05.2 гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл	99.2	100.0	100.0
05.3 гэр ахуйн цахилгаан бараа	104.8	100.0	100.0
05.4 гэр ахуйн шилэн эдлэл, сав суулга	122.1	100.0	100.0
05.5 гэр ахуй, цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгсэл	97.5	100.0	100.0
05.6 гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээ	113.9	100.0	100.0
06. эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
06.1 эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл	105.0	100.0	100.0
06.2 амбулаторын үйлчилгээ	100.0	100.0	100.0
06.3 эмнэлэгт хэвтэж үзүүлсэн үйлчилгээ	100.0	100.0	100.0
07. тээвэр	100.7	100.0	100.0
07.1 тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.0	100.0	100.0
07.2 хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	99.9	100.0	100.0
07.3 тээврийн үйлчилгээ	104.4	100.0	100.0
08. холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
09. амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.4	100.0	100.0
09.1 дуу, дүрс, гэрэл зураг, мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж	100.9	100.0	100.0
09.2 чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	100.0	100.0	100.0
09.3 ном, сонин, бичгийн хэрэгсэл	100.2	100.0	100.0
10. боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
11. зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	114.9	100.3	100.3
11.1 нийтийн хоолны үйлчилгээ	124.8	100.5	100.5
11.2 зочид буудал дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0	100.0
12. бусад бараа, үйлчилгээ	104.1	100.7	100.7
12.1 хувь хунд хандсан үйлчилгээ	104.9	100.8	100.8
12.2 хувь хүний эд зүйл, хэрэглэл	100.0	100.0	100.0
12.3 санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Орон нутгийн орлого	773.7	1197.0	154.7
Татварын орлого	172.5	536.5	311.0
Орлогын албан татвар	106.6	379.6	356.1
Өмчийн татвар	2.8	28.0	1000.0
Дотоодын бараа үйлчилгээний	0.8	-	-
Бусад	62.3	128.9	206.9
Татварын бус орлого	11.9	23.3	195.8
Хөрөнгийн орлого	0.7	-	-
Тусламжийн орлого	588.6	637.2	108.3

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүх зарлага	747.8	708.8	94.8
Бараа үйлчилгээний зардал	636.2	705.8	110.9
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	111.6	-	-
Хөрөнгийн зардал	-	3.0	-
Төсөвт байгууллагын тоо	47	51	108.5
Төсөвт байгууллагын ажиллагсадын тоо	751	769	102.4

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I		2016 I		$\frac{2016 I}{2015 I} \%$	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Авлага	11.7	10.2	18.2	22.2	155.6	217.6
Өглөг	14.8	155.9	302.7	339.0	2045.2	217.4



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Төрөл	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүгд	58	9	15.5
Ингэ	-	-	-
Гүү	-	-	-
Үнээ	8	4	50.0
Эм хонь	31	5	16.1
Эм ямаа	19	-	-

VII.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумдаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Сумд	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Дүн	58	9	15.5
Баянтал	-	-	-
Сүмбэр	57	-	-
Шивээговь	1	9	900.0

VII.3 ТӨЛ БОЙЖИЛТ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Төрөл	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүгд	58	9	15.5
Ботго	-	-	-
Унага	-	-	-
Тугал	8	4	50.0
Хурга	31	5	16.1
Ишиг	19	-	-

VII.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумдаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Сумд	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Дүн	58	9	15.5
Баянтал	-	-	-
Сүмбэр	57	-	-
Шивээговь	1	9	900.0



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Төрөл	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүгд	32	984	3075.0
Тэмээ	-	-	-
Адуу	-	26	-
Үхэр	1	53	5300.0
Хонь	12	323	2691.6
Ямаа	19	582	3063.2

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Сумд	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Дүн	32	984	3075.0
Баянтал	-	159	-
Сүмбэр	29	761	2624.1
Шивээговь	3	64	2133.3

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Төрөл	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүгд	3	111	3700.0
Тэмээ	-	-	-
Адуу	-	5	-
Үхэр	-	7	-
Хонь	1	23	2300.0
Ямаа	2	76	3800.0

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Сумд	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Дүн	3	111	3700.0
Баянтал	-	60	-
Сүмбэр	-	45	-
Шивээговь	3	6	200.0



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, жил бүрийн эхний 1 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Нийт	2895.1	5544.0	191.5
Уул уурхай	2653.7	5277.3	198.9
Нүүрс олборлолт	2653.7	5277.3	198.9
Дулааны эрчим хүч, усан хангамж	241.4	266.7	110.5
Дулаан	222.5	246.8	110.9
Усан хангамж	18.9	19.9	105.3

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 1 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Нийт	3399.1	4947.2	145.5
Уул уурхай	3157.6	4680.5	148.2
Нүүрс олборлолт	3157.6	4680.5	148.2
Дулааны эрчим хүч, усан хангамж	241.4	266.7	110.5
Дулаан	222.5	246.8	110.9
Усан хангамж	18.9	19.9	105.3

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Бүтээгдэхүүн борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	3157.6	4680.5	148.2
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.төг/	174.8	194.5	111.3
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.төг/	134.1	229.5	171.1
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр, сая.төг/	2653.7	5277.3	198.9
Ажиллагсадын тоо	495	595	120.2



IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Тээврийн орлого	Мян.төг	-	976.4	100.0
Зорчигч эргэлт	Мян.хүн	-	378.7	100.0
Зорчигчдын тоо	Мян.хүн	-	1.8	100.0
Ажиллагсадын тоо	тоо	-	10	100.0

X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 I	2016 I	$\frac{2016 I}{2015 I} \%$
Нийт орлого	сая.төг	18.8	15.3	81.4
Үүнээс: Хүн амаас	сая.төг	11.3	9.2	81.4
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1284	1246	97.0
Телефон цэг	тоо	415	354	85.3



Е-мэйл хаяг: govisumber@nso.mn

Вэб хаяг: www.govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг: www.1212.mn

Утас: 70543222, 70543017